



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn  
Вэбсайт: www.mof.gov.mn

2020.05.08 № 6-1/3105

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Зөвлөмж, чиглэл хүргүүлэх  
тухай

Дэлхий нийтийг хамарсан COVID-19 цар тахлыг даван туулах арга хэмжээний хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.5 дахь заалтад үндэслэн хуулийн 20, 34, 48 дугаар зүйл болон Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь заалтад үндэслэн ирүүлсэн зөвлөмжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулахтай холбогдуулан дараах чиглэлийг хүргүүлж байна.

1. Онцгой нөхцөл байдлын улмаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлд үндэслэн гэрээ байгуулсан тохиолдолд энэ тухай нээлттэй, ил тод мэдээлэх, иргэд олон нийтийг нэгдсэн мэдээллээр хангах, төрийн байгууллага, албан тушаалтныг аливаа эрсдэлээс хамгаалах, гарч болох авлига ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх;

2. Эдийн засгийн хүндрэлээс шалтгаан тендерт оролцогчдоос Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэгт үндэслэн тендерийн баталгааны хэмжээг 1 хувиар тогтоож тендерийн баримт бичигт тусгах;

3. 2020 оны эхний 4 сарын байдлаар худалдан авах ажиллагааны цахим (tender.gov.mn) сүлжээнд нийтлэгдсэн төлөвлөгөөнд олон тооны (нийт 779 удаа) өөрчлөлт орж байгаатай холбогдуулан 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрт үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу өөрийн багцын болон харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд шаардлагатай өөрчлөлтийг оруулан тус яаманд албан ёсоор шинэчлэн ирүүлж, батлагдсанаас хойш 3 хоногийн дотор Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д нийтлэх.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, ил тод байдлыг ханган, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах зөвлөмж, чиглэлийг үүгээр хүргүүлж байна.

*Ч.Хүрэлбаатар*

Ч.ХҮРЭЛБААТАР

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР  
УХА0583

Бүртгэсэн № *2309* Арт № ...  
Огноо *2/14* .....  
..... цаг ..... минутанд  
..... -д  
шилжүүлээ.